



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн байр, Тасганы овоо,
5 дугаар хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 7710 4949, Факс: (976) 7000 7021,
Цахим шуудан: contact@judcouncil.mn,
Цахин хуудас: www.judcouncil.mn

2025.10.21 № 01/1711
танай _____-ны № _____-т

БҮХ ШАТНЫ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ
ШҮҮГЧ, ШҮҮГЧ НАРТ

Нийт шүүгчийн чуулганы 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсныг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудастай.

ДАРГА *Цэцэгсүрэн* Н.МӨНГӨНЦЭЦЭГ



152506001501



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Н.МӨНГӨНЦЭЦЭГ ТАНАА

НИЙТ ШҮҮГЧИЙН ЧУУЛГАНЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Тасганы овоо,
Хувьсгалын зам-22, Шүүхийн ерөнхий зөвлөлийн байр,
Утас: 77104949 И-мэйл: contact@judges.mn

2025.10.15 № 43
танай _____ -ны № _____ -т

Тогтоол хүргүүлэх тухай

Нийт шүүгчийн III чуулган 2025 оны 10 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд Төрийн ордонд зохион байгуулагдсан.

Тус чуулганаар "Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам"-д нэмэлт өөрчлөлт оруулсан Нийт шүүгчийн чуулганы 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг хавсралтаар хүргүүлж байна.

Бүх шатны шүүхийн ерөнхий шүүгч, шүүгч нарт тогтоолыг хүргүүлж ажиллахыг хүсье.

Хавсралт ⁰³ хуудастай.

Хүндэтгэсэн,

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ

Б.БАТЦЭРЭН



НИЙТ ШҮҮГЧИЙН ЧУУЛГАНЫ ТОГТООЛ

2025 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалт, 20.5, 20.8 дахь хэсэг, Нийт шүүгчийн чуулганы 2021 оны 01 дүгээр тогтоолоор баталсан "Нийт шүүгчийн чуулганы хуралдааны дэг"-ийн 2.1.4, 8.1-т заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийт шүүгчийн чуулганы 2021 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нийтлэг журам"-д доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/2.3 дахь хэсэг:

"2.3.Шинээр томилогдсон, шилжин томилогдож ирсэн, сэлгэн ажилласан, хүндэтгэн үзэх шалтгаанаар удаан хугацаагаар эзгүй байсан буюу тойрогт шинээр орж байгаа шүүгчид шинээр ирсэн хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хуваарилах бөгөөд ийнхүү хуваарилалт хийхэд энэ журмын 1.2 дугаар хэсгийн 4-т заасан "хуваарилагдсан болон хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн нь Зөвлөгөөний шийдвэргүйгээр өөрчлөгдөх боломжгүй байх" зарчмыг баримтлан ачаалал тэнцвэржүүлэх аргыг хэрэглэх нөхцөл, журмыг шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон нарийвчилсан журмаар /цаашид "нарийвчилсан журам" гэх/ зохицуулж болно."

2/2.14 дэх хэсэг:

"2.14.Хуульд заасан үндэслэлээр танхим байгуулсанаас бусад тохиолдолд аймаг дахь сум дундын шүүх хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хуваарилахдаа шүүгчийн дарааллыг эрүү, иргэний хэргийн төрлөөр тойргийн багц үүсгэж байгаа бол энэ талаарх үндэслэл, хэрэгцээ, шаардлагыг нарийвчилсан журмыг батлах тухай тогтоолд тодорхой тусгах бөгөөд энэхүү тойрог үүсгэсэн дараалал шүүх бүрэлдэхүүнийг томилоход хамаарахгүй."

3/2.15 дахь хэсэг:

"2.15.Дээд шатны шүүхээс шийдвэр, тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан тохиолдолд урьд шийдвэрлэсэн шүүгч/бүрэлдэхүүн/-д дахин хуваарилах эсэхийг нарийвчилсан журмаар зохицуулна."

4/4.8 дахь хэсэг:

"4.8.Интернет сүлжээний доголдол, тасалдлаас шалтгаалан "Цахим шүүх 2.0" цөм системийн "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем" ажиллаагүй"

үед хэргийг хуваарилахдаа гараар хуваарилахгүй ба ирсэн огнооны дарааллыг баримтлан системд нөхөн бүртгэж зөвхөн системээс хуваарилах бөгөөд энэ тохиолдолд үйлдэл тус бүрийг дүрс бичлэг хийж хадгалах төхөөрөмжид хуулбарлан хадгална."

2."Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нийтлэг журам"-ийн хэсэг, заалтын дугаарлалтын "2.3" гэснийг "2.4" гэж, "2.4" гэснийг "2.5" гэж, "2.5" гэснийг "2.6" гэж, "2.6" гэснийг "2.7" гэж, "2.6.1" гэснийг "2.7.1" гэж, "2.6.2" гэснийг "2.7.2" гэж, "2.6.3" гэснийг "2.7.3" гэж, "2.7" гэснийг "2.8" гэж, "2.8" гэснийг "2.9" гэж, "2.9" гэснийг "2.10" гэж, "2.10" гэснийг "2.11" гэж, "2.13" гэснийг "2.12" гэж, "2.14" гэснийг "2.13" гэж тус тус өөрчилсүгэй.

3."Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нийтлэг журам"-ын дараах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/3.4 дэх хэсэг:

"3.4.Шүүх хуралдаан хойшилсон нь шүүх бүрэлдэхүүнийг өөрчлөх үндэслэл болохгүй бөгөөд бүрэлдэхүүнд томилогдсон шүүгч удаан хугацаагаар эзгүй байгаагаас бусад тохиолдолд шүүх бүрэлдэхүүнийг өөрчлөхгүй, өөр тойргийн багцаас шүүгч бүрэлдэхүүнд орохгүй."

2/3.6 дахь хэсэг:

"3.6.Бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх хэрэг, маргаанд шүүх хуралдаан даргалагч болон бүрэлдэхүүнд оролцох шүүгчийг хэд хэдэн шүүгчийн дунд тус тусад нь тойргийн багц үүсгэн сонгож болно."

3/4.1 дэх хэсэг:

"4.1.Нарийвчилсан журамд ээлжийн амралтаа эдэлж эхлэхээс тодорхой хугацааны өмнө, шүүгчид хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилалтыг зогсоохыг, ээлжийн амралтаа эдлээд ажилд ороход хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт тодорхой хугацааны өмнө хуваарилах эсэх, ээлжийн амралтын хугацаанд шүүх бүрэлдэхүүнд оролцох эсэх, хэрэг хянан шийдвэрлэх эсэх, ээлжийн амралтыг хувааж эдлэх тохиолдолд шүүгчид хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилалтыг аль хугацааны үед зогсоохыг тодорхой тусгана."

4/4.4 дэх хэсэг:

"4.4.Нарийвчилсан журмыг "Цахим шүүх 2.0" цөм системийн "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем"-д тохируулахдаа шүүхийн Тамгын газрын дарга, хэргийн хөдөлгөөний чиг үүрэг хариуцсан удирдах ажилтан, Ерөнхий шүүгчийн туслахын нарын хяналтын дор мэдээлэл технологийн мэргэжилтэн тохируулна."

4."Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нийтлэг журам"-ын 2.1, 2.2, 2.4, 2.8 дахь хэсгийн "нэгдсэн системд" гэснийг "Цахим шүүх 2.0" цөм системийн "Хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааны систем"-д" гэж, 2.6 дахь хэсгийн "нэгдсэн системээр" гэснийг "Цахим шүүх 2.0" цөм системийн "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем"-ээр" гэж, 2.7 дахь хэсгийн "нэгдсэн системээс" гэснийг "Цахим шүүх 2.0" цөм системийн "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем"-ээс" гэж, 2.9 дэх хэсгийн "программд" гэснийг "Цахим шүүх 2.0" цөм системийн "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем"-д" гэж тус тус өөрчилсүгэй.

5."Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нийтлэг журам"-ийн 3.1 дэх хэсгийн "шүүгчдийн зөвлөгөөнөөр урьдчилан тогтоосон" гэснийг хассугай.

6."Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нийтлэг журам"-ийн 1.5, 2.11, 2.12, 3.3 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

7.Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж, мөрдсүгэй.

ДАРГАЛАГЧ



Ц.ЦОГТ